

**“МОНГОЛ ШУУДАН” ХК-ИЙН 2025 ОНЫ
ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

Жилийн үйл ажиллагааны тайлан /маягт 1/				
Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайланг дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.				
Тайлагнах хугацаа		2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 31-ны өдөр		
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар		Нэр: “Монгол шуудан” ХК УБГД: 9012001026 ҮЦК: MNP, MN00MNP05412 Утас: 976 70078918, 976 11330788		
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр		Монголын хөрөнгийн бирж		
Бизнесийн үйл ажиллагааны салбар		Дотоод, гадаад шуудан хүргэлт, цахим худалдааны хүргэлт, тээвэр, логистик, гаалийн зуучийн үйлчилгээ, марк, дугтуй, ил захидал үйлдвэрлэл, худалдаа		
Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүргүүлсэн огноо		"ЦЭБЭ КОНСАЛТИНГ АУДИТ" ХХК		
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг		99,586,363 (ерэн есөн сая таван зуун наян зургаан мянга гурван зуун жаран гурав) ширхэг		
Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр		Бэлтгэсэн: ТУЗ-нийн нарийн бичгийн дарга Д.Цэцгээ Санхүү, төлөвлөлтийн газрын захирал Б.Нарандулам Хянасан: Гүйцэтгэх захирал Г.Тэлмэн Дэд захирал Н.Хосбаяр		
1.	Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/			
Санхүүгийн байдлын үзүүлэлт		Үзүүлэлт	Эхний үлдэгдэл (2025.01.01)	Эцсийн үлдэгдэл (2025.12.31)
		ХӨРӨНГӨ		
		Эргэлтийн хөрөнгө	25,540,296,202.27	19,409,328,297.39
		Эргэлтийн бус хөрөнгө	11,489,340,143.01	16,148,013,507.13
		Нийт хөрөнгө	37,029,636,345.28	35,557,341,805.13
		ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
		Өр төлбөрийн нийт дүн	11,404,970,851.02	9,702,632,327.66
		Эздийн өмч	25,624,665,494.26	25,854,709,477.47
		Нийт өр төлбөр ба эздийн өмч	37,029,569,832.88	35,557,341,805.13
Орлогын тайлан		Үзүүлэлт	Эхний үлдэгдэл (2025.01.01)	Эцсийн үлдэгдэл (2025.12.31)
		Борлуулалтын орлого (цэвэр)	23,894,295,918.89	25,423,475,974.10
		Борлуулалтын өртөг	21,896,067,590.24	24,540,234,067.30
		Үндсэн бус үйл ажиллагааны орлого	501,217,926.65	756,556,137.59
		Үндсэн бус үйл ажиллагааны зардал	2,048,302,996.58	1,508,611,115.51
		Бусад	(282,537,488.12)	387,243,593.07
		Татвар төлөхийн өмнөх ашиг	168,605,744.76	518,430,521.95
		Орлогын татварын зардал	32,587,849.41	45,882,258.59
		Татварын дараах ашиг	136,017,895.35	472,548,263.36

	Өмчийн өөрчлөлтийн тайлан	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл (2025.01.01)	Эцсийн үлдэгдэл (2025.12.31)	
		Эздийн өмч	9,958,636,300.00	9,958,636,300.00	
		Хуримтлагдсан ашиг	6,033,511,651.59	6,263,555,660.64	
	Мөнгөн гүйлгээний тайлан	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл (2025.01.01)	Эцсийн үлдэгдэл (2025.12.31)	
		Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(4,056,199,259.02)	(684,501,740.30)	
		Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(1,235,669,000.05)	(782,826,996.71)	
		Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(586,92,851.70)	(97,672,829.25)	
		Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(6,401,314,482.45)	(803,735,326.39)	
1.1	Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт				
	“Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол “Монгол шуудан” ХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.” гэж хөндлөнгийн аудит дүгнэн “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгсөн.				
1.2	Аудитын тодорхойлох захидал /тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх/				
	 ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР Засгийн газрын IV байр, Баян тогсруу 2, Чөлөөтний дүүрэг Улаанбаатар хот, 15180 Утас: 28 04 37, Факс: (976-51) 26 42 30, Цахим шуудан: info@audit.gov.mn, Цахим хуудас: www.audit.mn 2025.03.16 № 06/667 танай _____-ны № _____-г МОНГОЛ ШУУДАН ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Г.ТЭЙМЭН ТАНАА Дээрх зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.8 дахь заалтуудтай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын "нийцсэн ба зохистой байх", "үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна. Асуудлыг онцолсон хэсэг "Тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын албан журмын даатгал"-ын тендер сонгон шалгаруулалтаар Ард даатгал ХХК-тай 37.0 сая төгрөгийн даатгалын үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулсан байна. Аудитын гол асуудал Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй. Монгол шуудан ХК-д Төв аймгийн Сэргэлэн сум, Хөшгийн хөндийд хувьцаа эзэмшигчдийн хөрөнгөөр баригдсан "Олон улсын шуудангийн илгээмж, ангилан ялгах, гаалийн хяналтад оруулах орлогцолбор төв"-ийн 5,358.2 сая төгрөгийн өртөг бүхий 2 давхар барилгын газрыг Зам тээврийн яамнаас 2025 оны "нөхөн төлбөргүйгээр газрыг чөлөөлөх тухай" 03/3346 дугаар бүхий мэдэгдэл мөн Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт ХХК-иас 2025 оны "Ус дулааныг зогсоох тухай" EG-0A/176 дугаартай албан бичиг ирж 8 дугаар сарын 31-ний өдрөөс ус дулааны хэрэглээг хязгаарласан нь ялган боловсруулах төвийн барилгад эрсдэлтэй нөхцөл үүссэн байна. Бусад асуудлын хэсэг Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу аудитын мөрөөр хяналт тавих арга хэмжээ буюу өмнөх аудитаар өгсөн аудитын шийдвэрт дурдсан асуудлыг шалгадагч байгууллага хэрхэн хэрэгжүүлж, шийдвэрлэснийг аудитор хянаж, үнэлэх үүрэг хүлээдэг. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно. Удирдлага болон Засаглал эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ. Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.				
2.	Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл				
2.1	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	Эргэлтийн харьцаа=ЭХ/БХӨТ=2.00 Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар=(БМ+БХХО+Авлага)/БХӨТ=1.52 Өрийн харьцаа=Нийт ӨТ/НХ=0.27			

2.2	<i>Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт</i>	Өр төлбөр эздийн өмчийн харьцаа=Нийт ӨТ/ЭӨмч=37.5% Нийт хөрөнгийн өгөөж=БО/цэвэр/Нийт хөрөнгө= 1.33
2.3	<i>Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл</i>	Гадаад орчны нөлөөлөл: - Цахимжилт, интернэтийн хөгжлөөс шалтгаалан бичиг захиа, хэвлэл захиалга зэрэг уламжлалт шуудангийн үйлчилгээний эрэлт буурч байна. - Харин цахим худалдааны өсөлт нь шинэ боломжийг бий болгож байна - Технологийн хөгжил, зах зээлийн өөрчлөлт нь уламжлалт дэд бүтцийг шинэчлэх, шинэ нэр төрлийн үйлчилгээ нэвтрүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтын хэрэгцээг нэмэгдүүлж байна. - Дэлхий дахинд хил дамнасан цахим худалдаа эрчимтэй хөгжиж байгаа нь олон улсын логистик, хүргэлтийн зах зээлд өрсөлдөх боломжийг бүрдүүлж байна. - Валютын ханшийн хэлбэлзэл, төгрөгийн сулрал нь зардлыг өсгөж, ханшийн эрсдэлийг нэмэгдүүлж байна. - Зах зээл дэх өрсөлдөөн идэвхжиж, дотоодын болон гадаадын өрсөлдөгчдийн тоо нэмэгдсэнээр үнийн өрсөлдөөн ширүүсэж, ашигт ажиллагаанд нөлөөлөх эрсдэл үүсэж байна. - Шатахууны хомсдол, үнийн өсөлт нь үйлчилгээний өртгийг нэмэгдүүлж, зардлын дарамтыг бий болгож байна. - Ажиллах хүчний хомсдол, өндөр эргэлт нь үйлчилгээний чанарт нөлөөлөх хүчин зүйл болж байна. Дээрх сорилтуудыг даван туулах чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээ: - Уламжлалт дэд бүтцийг орчин үеийн зах зээлийн шаардлагад нийцсэн, уян хатан, өндөр бүтээмжтэй дэд бүтэц болгон шинэчлэхэд хөрөнгө оруулж байна. - Технологи, автоматжуулалтыг нэвтрүүлж, хүчний нөөцөөс хамаарах хамаарлыг бууруулж байна. - Гадаад зэх зээлийг тэлж, валютын орлогыг нэмэгдүүлэх замаар ханшийн эрсдэл, зардлын өсөлтийг саармагжуулж байна. - Цахим систем, платформ хөгжүүлэлтэд хөрөнгө оруулж, олон улсын цахим худалдааны платформуудтай интеграц хийж, шинэ үйлчилгээ нэвтрүүлж байна - Зардлын тогтворвортой байдлыг хангах зорилгоор хэджинг (hedging) стратегийг хэрэгжүүлж байна.
2.4	<i>Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого</i>	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээ байхгүй.
2.5	<i>Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл</i>	Байхгүй
3.	<i>Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/</i>	
	Тайлант хугацаанд 2 удаагийн сонирхлын зөрчилтэй хэлцэл хийсэн. - Мөнгөн хөрөнгийн чөлөөт үлдэгдлийн ашиглалтыг сайжруулах, үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор компанийн 1,000,000.00 (нэг сая) ам.долларыг 6 сарын хугацаатай, 4%-ийн хүүтэй хадгаламжид байршуулахаар “Ард кредит” ББСБ ХК-тай хэлцэл хийв. - Дээрх хэлцлийг 6 сарын хугацаагаар үргэлжлүүлэн байршуулах хэлцэл хийв.	


4.	<i>Цалин урамшууллын мэдээлэл</i>
	Төлөөлөн удирдах зөвлөл нь 2025 онд цалин болон бусад зардалд 241.1 сая төгрөг зарцуулсан байна. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн ХЭ-25/02 дугаар тогтоолоор ТУЗ-ийн гишүүдийн сарын цалинг доорх дүнгээр баталсан. ТУЗ-ийн дарга-1,800,000 төг ТУЗ-ийн дэргэдэх хороодын дарга-1,680,000 төг ТУЗ-ийн бусад гишүүд- 1,560,000 төг
5.	<i>Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл</i>
	Засаглалийн бүтэц, үйл ажиллагаа <u>Хувьцаа эзэмшигчдийн хурал</u> Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 10:00 цагт “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн “MSE HALL” хурлын танхимд зохион байгуулагдав. Хурлаас гарсан шийдвэрүүд: 1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлав. 2. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны зардлын төсвийг батлав. <u>Төлөөлөн удирдах зөвлөл</u> “Монгол шуудан” ХК-ийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал бөгөөд түүний чөлөөт цагт компанийн үйл ажиллагааг Хувьцаа эзэмшигчдийн хурлаас томилогдсон төлөөлөн удирдах зөвлөл удирддаг. ТУЗ нь есөн гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж, компанийн бизнесийг дэмжих, өргөжүүлэх, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх чиглэлээр дэргэдээ байнгын ажиллагаатай 3 хороотой ажиллав. Хороодын хараат бус байдлыг бүрэн хангах зорилгоор хараат бус 3 гишүүнийг бүх хорооны бүрэлдэхүүнд ажиллуулсан. Тайлант хугацаанд ТУЗ нь 89 хувийн дундаж ирцтэйгээр 13 удаа /эчнээ, цахим, танхим/ хуралдаж, нийт 37 асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэж, 24 тогтоол, 8 тэмдэглэл батлан, хэрэгжилтэд хяналт тавин ажилласан. <u>Компанийн засаглал:</u> Санхүүгийн зохицуулах хорооноос үнэлдэг “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн үнэлгээний баталгаажуулалтаар 2025 онд 84.7 хувьд хүрч компанийн дотооддоо мөрдөх бодлогын баримт бичиг, дүрэм журам, зааврыг засаглалын зарчимд нийцүүлэн баталгаажуулж, хэрэгжүүлж ажиллав. <u>Мэдээллийн ил тод байдал:</u> Компани Шилэн дансны тухай хууль болон Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу 62 нэр төрлийн мэдээлэл буюу Худалдан авах ажиллагаа, хөрөнгө оруулалт, хүний нөөц, төсөв санхүүтэй холбоотой мэдээллүүдийг https://shilendans.gov.mn/, https://www.tender.gov.mn/mn, https://mse.mn/mn, болон өөрийн байгууллагын https://www.mongolpost.mn/ сайтад байршуулан ажиллах үүрэгтэй бөгөөд тайлант хугацаанд мэдээллүүд бүрэн, ил тод байршин хувьцаа эзэмшигчид болон оролцогч талуудад мэдээллийг хүргэсэн. Тайлант хугацаанд ажилласан ТУЗ-ийн гишүүдийн мэдээлэл: 1. Даваахүү НАРАНГЭРЭЛ Ердийн гишүүн, ТУЗ-ийн дарга 2. Даваасамба ДЭЛГЭРМАА Ердийн гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны дарга 3. Даваадорж БАЛЖИННЯМ Ердийн гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын хорооны гишүүн

4. Хаш-Эрдэнэ Сүрэнхорол
Ердийн гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны гишүүн
5. Одончимэд ОДБАЯР
Ердийн гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын хорооны дарга
6. ГалнямУЯНГА
Ердийн гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын болон Нэр дэвшүүлэх хорооны гишүүн
7. Банзрагч ГАНБААТАР
Хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын, Нэр дэвшүүлэх болон Цалин урамшууллын хорооны гишүүн
8. Дарамбазар БАЛДОРЖ
Хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дарга, Нэр дэвшүүлэх болон Цалин урамшууллын хорооны гишүүн
9. Чүлтэм АМАРБААТАР
Хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын, Нэр дэвшүүлэх болон Цалин урамшууллын хорооны гишүүн

Удирдлагын баг

1. Гэрэлт ТЭЛМЭН - Гүйцэтгэх захирал
2. Нанзад ХОСБАЯР - Олон улсын бизнес хамтын ажиллагаа хариуцсан дэд захирал
3. Даваахүү БАТТУЛГА – Салбар удирдлагын газрын захирал
4. Орсоо САРАНГЭРЭЛ – Улс хоорондын шуудангийн газрын захирал
5. Ганболд ГАНЧИМЭГ – Санхүү, төлөвлөлтийн газрын захирал
6. Очирлхагва ОТГОНБАЯР – Хүний нөөц, үйл ажиллагааны газрын захирал
7. Санжжав СУВДАНГЭРЭЛ – Мэдээллийн технологийн газрын захирал
8. Алтангэрэл НАНДИН-ЭРДЭНЭ – Шуудан, логистикийн газрын захирал
9. Билэгт ТАМИР – Бизнес хөгжлийн газрын захирал

Компанийн бүтэц

	“МОНГОЛ ШУУДАН” ХК-ИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ ЦАЛИН УРАМШУУЛЛЫН ХОРОО НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРОО АУДИТЫН ХОРОО ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ДОТООД АУДИТОР ДЭД ЗАХИРАЛ ХҮНИЙ НӨӨЦ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР АНХ АХУЙ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБА САНХҮҮ, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗАР ХҮРГЭЛТ, ЛОГИСТИКИЙН АЛБА АВТОБААЗ ЯЛГАН БОЛОВСРУУЛАХ ТӨВҮД ШУУДАН, ЛОГИСТИКИЙН ГАЗАР ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ АЛБА БИЗНЕС ХӨГЖЛИЙН ГАЗАР ОЛОН УЛСЫН АГААРЫН ШУУДАН, ЯЛГАН БОЛОВСРУУЛАХ ТӨВ ОЛОН УЛСЫН ГАЗАР ШУУДАН ЯЛГАН БОЛОВСРУУЛАХ ТӨВ УЛС ХООРОНДЫН ШУУДАНГИЙН ГАЗАР МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ГАЗАР САЛБАР УДИРДЛАГЫН ГАЗАР АЙМГИЙН ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРУУД ДУРГИЙН ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРУУД СУМЫН ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРУУД ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ХЭЛТЭС ХЯНАЛТ, ШИНЖЛЭГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ЛАВЛАХ ТӨВ МАРК, ҮНЭТ ЦААСНЫ ХЭЛТЭС ҮНЭТ ЦААС БЭЛТЭГН НҮЙЛЛҮЛЭХ ТӨВ																
6.	<i>Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл</i>																
	Зах зээлийн эрэлтийн эрсдэлд: Уламжлалт шуудан (захидал, хэвлэл) үйлчилгээ буурах хандлагатай ба дижитал шилжилт → бичиг баримт, мэдээлэл цахим болж, компанийн орлогын бүтэц өөрчлөгдөж байна. Өрсөлдөөний эрсдэлд: Олон улсын courier, хувийн логиستيкийн операторууд, дотоодын хувийн хүргэлтийн компаниудын үйл ажиллагаа үнэ бууруулах дарамт, хүргэлтийн хурд, чанарын өрсөлдөөн, зах зээл хувийг багасгах эрсдэл болон олон улсын шуудангийн төлбөр тооцоонд үүсэх валютын ханш, төгрөгийн үнэ цэнгийн бууралт, инфляцын нөлөөллийн эрсдэл ханшийн хэлбэлзлийн нөлөөлөл байдаг.																
7.	<i>Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэр эзэмшлийн хувь нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/</i>																
	Тайлант хугацаанд Монголын хөрөнгийн биржийн I ангилалд багтсан амжилтаа бататгаж, хувьцаа эзэмшигчдийн тоо 3,438-д хүрч 2025 оны туршид 0.2 тэрбум төгрөгийн 295 мянган ширхэг хувьцаа Монголын хөрөнгийн биржээр арилжаалагдсан байна. Хувьцаа эзэмшлийн хувь <table><tr><th>Хувь</th><th>Төрлийн</th><th>Ард Санхүүгийн Нэгдэл ХК болон түүний охин компаниуд</th><th>Бусад</th></tr><tr><td>66%</td><td>Төрийн</td><td></td><td></td></tr><tr><td>26%</td><td></td><td>Ард Санхүүгийн Нэгдэл ХК болон түүний охин компаниуд</td><td></td></tr><tr><td>8%</td><td></td><td></td><td>Бусад</td></tr></table>	Хувь	Төрлийн	Ард Санхүүгийн Нэгдэл ХК болон түүний охин компаниуд	Бусад	66%	Төрийн			26%		Ард Санхүүгийн Нэгдэл ХК болон түүний охин компаниуд		8%			Бусад
Хувь	Төрлийн	Ард Санхүүгийн Нэгдэл ХК болон түүний охин компаниуд	Бусад														
66%	Төрийн																
26%		Ард Санхүүгийн Нэгдэл ХК болон түүний охин компаниуд															
8%			Бусад														
8.	<i>Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээ</i>																
	Тайлант хугацаанд Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргаагүй болно.																

9.	Ногдол ашигийн мэдээлэл
	2024 оны ногдол ашгийг 2025 оны 05 дүгээр сарын 25-ны өдөр “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-иар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн үнэт цаасны хадгаламжийн дансанд шилжүүлэх замаар 100% олгосон. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 26/07 дугаар тогтоолоор компанийн 2025 оны жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн тайлангаарх цэвэр ашгаас 31.6 хувь буюу нэгж хувьцаанд 1.5 (нэг төгрөг тавин мөнгө) төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдөр буюу 2026 оны 04 дүгээр сарын 03-ны өдрөөр тогтов.
10.	Үнэт цаас гаргагчаас тайлант хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл • <u>“Сайхан сэтгэлийн илгээмж” аян</u> Тус аяны хүрээнд дотоод шуудангийн үйлчилгээнээс 100 төгрөг, гадаад шуудангийн үйлчилгээнээс 1,000 төгрөгийг тус тус хуримтлуулж, Сонгино хайрхан дүүгийн 152 дугаар сургууль (Улаанчулуут) болон Баянзүрх дүүгийн 85 дугаар сургууль (Гацуурт)-д 81 багц бүтэн жилийн хийчээлийн дэвтэр хандивлав. Энэхүү үйл ажиллагаа нь зөвхөн хандив бус боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх, хүүхдүүдийн сурч боловсрох эрхийг дэмжих, ирээдүйд чиглэсэн хөрөнгө оруулалт болсон. • <u>“Гадаадад суралцах мөрөөдлөө Монгол шуудантай хамт эхлүүлээрэй” аян</u> Гадаадын их, дээд сургуульд материалаа илгээж буй сурагч, оюутнуудад зориулан гадаад шуудангийн зардалыг 10-20 хувийн хөнгөлөлт үзүүлж, тэдний боловсролын зорилгыг дэмжив. • <u>Гар бичмэл захидлын уралдаан</u> Ард Санхүүгийн Боловсрол НҮТББ болон Монгол Нэт компанитай хамтран “Хэрвээ би байгаль байсан бол...” сэдэвт гар бичмэл захидлын улсын уралдааныг зохион байгуулж, хүүхдүүдийн бүтээлч сэтгэлгээ, төсөөллийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэв. • <u>“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд оролцоо</u> Монгол Улсын ерөнхийлөгчийн санаачилсан энэхүү хөдөлгөөнд нэгдэн уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг бууруулах, ой, усны нөөцийг хамгаалах, экологийн тэнцвэрийг хадгалах, мод тарих соёлыг түргэн дэлгэрүүлэх үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, бодит хувь нэмэр оруулан ажиллав. • <u>Цахим шилжилт ба байгаль орчинд үзүүлэх нөлөө</u> Компанийн дотоод үйл ажиллагааг цахимжуулах хүрээнд E-Geree системийг нэвтрүүлж, гэрээ байгуулах үйл явцыг бүрэн цахимжуулав. • <u>Ахмадын хороо болон ахмад настны дэмжлэг</u> Компани дэргэдээ “Ахмадын хороо”-г байгуулан жил бүр тогтмол хамтран ажиллаж, ахмад настнуудад чиглэсэн төрөл бүрийн үйл ажиллагааг зохион байгуулж байна. 2025 онд олон жил үр бүтээлтэй ажилласан 500 гаруй ахмад ажилтнуудад Ахмад настны тухай хуулийн хүрээнд нийт 60 гаруй сая төгрөгийн дэмжлэг, тусалцаа үзүүлж, тэдний нийгмийн баталгаа, амьжиргааг дэмжин ажиллав.
Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:	
Овог, нэр: Т.Элмэн ХК Албан тушаал: “Монгол шуудан” ХК-ийн гүйцэтгэх захирал Гарын үсэг: (Тамга, тэмдэг) 2116545 1116 22141	Овог, нэр: Б.Нарандулам Албан тушаал: “Монгол шуудан” ХК-ийн Санхүү төлөвлөлтийн газрын захирал Гарын үсэг: (Тамга, тэмдэг)
Мэдээлэл баталсан этгээдийн гарын үсэг, огноо:	
Овог, нэр: Д.Цэцгээ Албан тушаал: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Гарын үсэг: Огноо: 2026.04.29	